



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 8/4/2

Бөхт

Г Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 109 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх “ Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны засварын ажил, Шинээр өвс тэжээлийн агуулах барих ажил”-ын зураг төсөв боловсруулсан зөвлөх үйлчилгээний ажлын урьдчилгаанд 7,000,000(Долоон сая)төгрөгөөр Чулуутын багш ХХК-тай шууд гэрээ байгуулсугай.
2. “Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны засварын ажил, Шинээр өвс тэжээлийн агуулах барих ажил”-ыг ажлын даалгаврын дагуу стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэхийг Чулуутын багш ХХК-ны захирал (Ж.Мөнх-Очир)-т даалгасугай.
3. “Чулуутын багш ” ХХК-тай шууд гэрээ байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д, ажлын уялдааг хангаж, хамтарч ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Мөнхбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

У.АЛТАНХҮҮ

